



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/098/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот</p> <p>2025 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Долгорсүрэн Утас: 261740 Цахим хаяг: Dolgorsurenb@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: П.Амарсанаа Утас: 261648 Цахим хаяг: Amarsanaap@audit.gov.mn</p> <p>Аудитор: Н.Нямсүрэн Утас: 261648 Цахим хаяг: Nyamsuren@audit.gov.mn</p> <p>Аудитор: М.Ганбаатар Утас: 261648 Цахим хаяг: Ganbaatarm@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ж.Мөнхтуул Утас: 261648 Цахим хаяг: Munkhtuulj@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ТӨҮГ-ЫН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Г.ЁНДОН
ТАНАА

2025.03.14 № 1027
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- "Белаз хүнд даацын өөрөө буулгагчийн сэлбэг, эд ангийг худалдан авах" тендерт Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ авах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ыг мөрдөж, нэг эх үүсвэрээс худалдан авах аргыг ашиглаж эхэлсэнтэй холбоотойгоор Беллинк ХХК-тай тайлант онд 7,621.4 сая төгрөгийн 2 гэрээг байгуулсан. Тус хуулийн этгээд нь адил төстэй бараа нийлүүлэх 6 удаагийн нээлттэй тендерт санал өгч, оролцогчийн ерөнхий нөхцлийн шаардлага хангаагүй, 2024 онд байгуулагдсан, гэрээнд заасан хугацаанд барааг нийлүүлээгүй зэрэг зөрчилтэй байгаагаас гэрээний үүргээ хэрэгжүүлэхгүй байх, найдваргүй авлага үүсгэх эрсдэлтэй байна;
- Төрийн өмчит үйлдвэрийн газрыг түшиглэн үйлдвэрлэл, технологийн парк байгуулах зорилтын хүрээнд зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах металлург-химийн үйлдвэр, (HL-SX/EW) технологиор катодын зэс үйлдвэрлэх арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах зардалд нийт 4,115.3 сая төгрөгийг зарцуулсан боловч төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүй, хөрөнгө оруулалтын ажлын төсөвт өртөг нэмэгдэх эрсдэл үүссэн, шаардагдах санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй;

- Өмнөх онуудад үүссэн Медипас ХХК-ийн нэхэмжлэлтэй Сингапурын Олон Улсын Арбитрын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 012 дугаартай шийдвэрийн хэрэгжилтийг хангаж төлөвлөөгүй зардлыг мөнгөн урсгалаас төлсөн нь үйлдвэрийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварт нөлөөлсөн;
- Ашиглалтад байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 25033 нэр төрлийн 546,582.1 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаагаас цаашид ашиглах боломжтой эсэхийг тодорхойлж, ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоогоогүй, санхүүгийн тайланг бодит үнэ цэнээр тайлагнаагүй;
- Санхүүгийн тайланд урьдчилж гарсан зардал/тооцооны 55,374.0 сая төгрөгийн үлдэгдэлд хуулийн байгууллагад шилжүүлсэн, шүүхийн шатанд байгаа 81 хуулийн этгээдийн 17,677.1 сая төгрөгийн урьдчилгааны үлдэгдэл байна. Найдваргүй болох эрсдэлтэй гэрээт ажил, бэлтгэн нийлүүлэгчид олгосон урьдчилгаа үүссэн шалтгаан болон тендерийн баримт бичиг, шалгарсан тендерийн үр дүнгээс үзэхэд анхны гэрээ, хэлцэл байгуулагдсны дараа тухайн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан урьдчилгаа төлбөрийн нөхцлийг нэмж тусган төлбөрийг бүрэн олгох, анх тохирсон хугацаанаас хойш удаа дараа өөрчлөлт оруулан хугацааг сунгасан зэргээс шалтгаалан захиалагч тал гэрээний хэрэгжилтийг бүрэн хангуулж чадахгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2-т "Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээний үүргийн гүйцэтгэлийн явцад дараах зүйлийг хориглоно", 40.2.1-т "энэ хуулийн 40.1-д зааснаас бусад үндэслэлээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах", 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Засгийн газрын 2019 оны 102 тогтоолоор баталсан "Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрэм"-ийн 6.11.1-т "үйлдвэрийн газрын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах", Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2023 оны А/807 дугаар тушаалаар баталсан "Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаанд баримтлах бодлого"-ын 2.1.4-т "Худалдан авах үйл ажиллагаа нь ил тод, өрсөлдөх тэгш боломжийг хангасан, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7-д "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулснаас хойш ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлангаар ногдуулсан дүнд өөрчлөлт оруулан өр төлбөрийг нэмэгдүүлж, өмнөх оны 1,197.9 сая төгрөгийн төлбөрийг төлсөн нь тус үйлдвэрийн 2024 оны аудит хийсэн тайлан гарснаас хойш татварын тайланд өөрчлөлт орох, тайлант оны төлбөр дараагийн жилд шилжин төлөгдөж болзошгүй байна.

Засгийн газрын 2022 оны 138 дугаар тогтоолоор хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Эрдэнэт медиал төрийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг байгуулсныг 46,769.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар санхүүгийн тайланд бүртгэсэн байна.

Монголиан Смелтинг Корпорэйшн ХХК-ийн өмчлөл дах Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Лондон хот дахь үл хөдлөх хөрөнгө, гарсан гүйлгээг аудитад хамруулж, харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгүүлэхээр бэлтгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд нийгмийн цех, нэгжүүдийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр өөрийн орлогоос 15,765.4 сая төгрөг, урсгал зардалд 80,051.0 сая төгрөг, хөрөнгийн зардалд 943 арга хэмжээнд 18,251.3 сая төгрөгийг тус тус баталсан байна. Гүйцэтгэлээр 65,270.7 сая төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулж, тайлант оны 64,285.6 сая төгрөгийн алдагдлыг нийгмийн хариуцлагын хүрээнд санхүүжүүлсэн нь үйлдвэрийн ашигт ажиллагааг буруулж, шууд бус зардлыг нэмэгдүүлж байна. Цаашид төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасны дагуу уул уурхайн салбарын дэд бүтцээр дамжуулан олон нийтэд үйлчилгээ үзүүлэх боломжтой нэгжийг хувийн секторт хуульд заасан түншлэлийн хэлбэр, санхүүжилтийн төрлийг оновчтойг сонгож, төсөл хэрэгжүүлэх нь дунд хугацаанд нийгмийн цехүүд биеэ даах, инфляцын дам нөлөөгөөр үүсэх үйлдвэрийн зардлын ачаалал, цехүүд рүү чиглэсэн шууд болон шууд бус зардлуудыг бууруулахаар байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор уул уурхайн хүнд машин, механизм, тоног төхөөрөмж, үйлдвэрийн үндсэн үйл ажиллагаанд шаардлагатай орц, бүтээгдэхүүн, таваар зэргийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа нээлтэй тендер шалгаруулалтын аргаас зайлсхийж, нэг эх үүсвэрт хамруулахаар төлөвлөх, шаардлага хангахгүй хуулийн этгээд шалгарах, урьдчилгаа төлбөр олгох эрсдэл үүсэж болзошгүй байна.

Дээрх нөхцөлүүдээс шалтгаалсан санхүүгийн тайлангийн уламжлалт эрсдэл бүхий материаллаг найдваргүй авлага, урьдчилгаа төлбөр/тооцооны үлдэгдэлд хасагдуулга хийх, шүүх, хууль, хяналтын байгууллагад шилжсэн асуудлуудын хөөн хэлэлцэх хугацаа дуусах зэрэг эрсдэлүүд бий болж болзошгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Лондонгийн металлын бирж, Платтс металл дээрх арилжааны цэвэр зэс, молибдены оксидын дундаж үнэ нэмэгдэж, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын экспортын 1 тонн тутмын баяжмалын борлуулалтын үнийн өсөлтөөс 165,667.0 сая төгрөг олж, 126,947.2 сая төгрөгийн ханшийн алдагдал хүлээсэн байна. Тус үйлдвэр 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг төлөвлөсөн түвшинд хүргэж, гүйцэтгэлийг хангаж ажилласан байна.

Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлтийн биелэлтийг хянаж үзэхэд 41.0 сая.тн хүдэр олборлож, 38.0 сая.тн хүдэр боловсруулж, 127.5 мян.тн зэс агуулсан 568.2 мян.тн зэсийн баяжмал, 2.8 мян.тн молибден агуулсан 5.5 мян.тн молибдены баяжмал үйлдвэрлэж төлөвлөгөөнөөс хүдрийг 138.0 мян.тонноор илүү олборлож, 20.0 мян.тонноор илүү

боловсруулж, 6.2 тн зэсийн, 178.4 тн молибдены баяжмалыг тус тус илүү үйлдвэрлэсэн байна.

Монгол Улсын 2025 оны нүүрсний экспортын нийлүүлэлтээс үүссэн төлбөрийн тэнцлийн алдагдлын нөлөөгөөр төгрөгийн ам.доллартой харьцах ханшийн уналт үйлдвэрийн цэвэр ашгийн хэмжээг бууруулж болзошгүй байна. Олон улсын зах зээлд цэвэр зэс, молибдены үнэ өсөх хандлагатай байгаа тул уурхай үйл ажиллагааг тогтмолжуулан нийлүүлэлтийн биет хэмжээг нэмэгдүүлж, цаашид зах зээлийн тодорхой бус байдлаас үүсэж болзошгүй эрсдэлээс хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

Засгийн газрын тогтоол, зарим аймгийн Засаг даргын Тамгын газартай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу 2024 онд нийгмийн хариуцлагын хүрээнд нийт 142,867.5 сая төгрөгийн дараах арга хэмжээг санхүүжүүлсэн нь үйлдвэрийн ашигт ажиллагааны түвшнийг бууруулж байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 127 дугаар тогтоолоор төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, сургуулийн дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих төсөл, арга хэмжээнд 39,901.4 сая төгрөг;
- "Шинэ Хархорум хотын төв цэг, төв талбайн тохижилтын ажлын санхүүжилтийн тухай" Засгийн газрын 2024 оны 221 дугаар тогтоолоор 20,000.0 сая төгрөгийн санхүүжилтийг Хот, байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд шилжүүлсэн;
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Монголросцветмет ТӨҮГ, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2024 онд байгуулсан хамтран ажиллах гурван талт гэрээний дагуу "Бэрхийн уурхайд суурилсан "Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв" төслийн бүтээн байгуулалтад 3,087.3 сая төгрөгийн дэмжлэгийг Монголросцветмет" ТӨҮГ-т шилжүүлсэн;
- "Дархан арьс ширний цогцолборын хөрөнгө оруулалтын талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 2022 оны 09 дүгээр тогтоолоор 2,311.9 сая төгрөг;
- "Монгол Улсын сурталчлах тухай" 2024 оны 175 дугаар тогтоолын хүрээнд Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 01 дугаар шийдвэрээр Парис-2024 зуны олимпын үеэр Монгол Улсыг сурталчлах Монголиа хаус төслийн санхүүжилтэд 200.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон;
- "Орхон аймаг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай байгуулсан 2021 оны 5/294-21 дүгээр хамтран ажиллах гэрээгээр 2,361.2 сая төгрөг, Орхон, Эрдэнэт хот доторх авто замын засвар, шинэчлэлийн ажилд 20,000.0 сая төгрөг, Эрдэнэт үйлдвэр, Эрдэнэт хотыг бүтээн байгуулсан анхдагч илгээлтийн эздийн 50 жилийн ойд 3,000.0 сая төгрөгийг ЗДТГ, ОНХС-д тус тус олгосон;
- Булган аймаг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай байгуулсан 2021 оны 5/295-21 дүгээр хамтран ажиллах гэрээгээр 1,000.0 сая төгрөг, "Дэлхийн Алтаргана 2024" наадмыг зохион байгуулахад 1,000.0 сая төгрөгийн дэмжлэгийг Булган аймгийн ЗДТГ-т олгосон;
- Завхан аймгийн ЗДТГ, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай байгуулсан 2024 оны 5/098-24 дүгээр хамтран ажиллах гэрээгээр 200.0 сая төгрөгийн дэмжлэгийг Завхан аймгийн ЗДТГ-т олгосон.
- "Уурхайчин-2 болон 3" орон сууцны хороолол хүртэлх дэд бүтцийн 49,436.3 сая төгрөгийн шугам, сүлжээний ажил дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй. ТӨБЗГ-ын 2024 оны 700 дугаар тогтоолоор 2025 онд шилжүүлэн өгөхөөр шийдвэрлэсэн байна.

Хууль, шүүхийн байгууллагад шилжүүлсэн зарим асуудлын явц, үр дүнгийн талаар цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан аудитын хангалттай, зохистой нотолгоог олж аваагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАГДЖАВ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	47,500,605,184.62	36,799,102,651.29
1.1.2	Дансны авлага	20,931,005,179.40	11,528,402,557.57
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	19,195,041,533.18	2,266,965,651.47
1.1.4	Бусад авлага	3,804,140,984.53	5,050,207,981.11
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	592,511,564,454.76	605,359,487,916.23
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	56,809,356,118.60	55,374,066,665.55
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	336,000,000.00	527,527,625.14
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	741,087,713,455.09	716,905,761,048.36
1.2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,492,571,730,930.56	2,923,619,694,058.16
1.2.2	Биет бус хөрөнгө	2,480,787,302,520.96	2,481,453,520,095.30
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	60,034,852,802.27	60,746,826,142.65
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	58,920,951,808.26	76,252,598,868.12
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	107,615,809,053.00	112,721,091,075.41
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	575,486,893.09	1,287,860,000.09
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	300,690,628,692.46	298,162,535,497.15
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,501,196,762,700.60	5,954,244,125,736.88
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,242,284,476,155.69	6,671,149,886,785.25
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	111,476,635,215.09	177,997,053,720.12
2.1.1.2	Цалингийн өглөг	34,079,351,874.73	38,406,409,691.90
2.1.1.3	Татварын өр	4,456,378,017.23	106,241,265,052.33
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	342,059,000,000.00	342,031,799,863.14
2.1.1.6	Хүүний өглөг	1,378,394,824.11	581,318,789.56
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	111,981,533,413.88	167,981,050,813.48
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	55,759,782,285.00	57,061,878,802.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	49,078,849,918.02	45,396,307,419.71
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгөнд хамаарах өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөрийн дүн	710,269,925,548.06	935,697,084,152.24
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	263,981,690,647.86	257,888,721,307.33
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	73,433,563,315.56	59,175,515,162.01
2.1.2.4	Бусад урт хугацаат өглөг		
2.1.2	Урт хугацаат өр төлбөрийн дүн	337,415,253,963.42	317,064,236,469.34
2.1	Өр төлбөрийн нийт дүн	1,047,685,179,511.48	1,252,761,320,621.57
2.3	ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.3.1	Өмч: а) Төрийн	2,658,321,900.00	2,658,321,900.00
2.3.2	б) Хувийн	-	-
2.3.3	Халаасны хувьцаа		
	Хувьцаат капиталын дүн	2,658,321,900.00	2,658,321,900.00

2.3.4	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.5	Дахин үнэлгээний нөөц	477,796,557,719.90	477,667,116,719.90
2.3.6	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	2,475,166,939,337.00	2,475,166,939,337.00
2.3.7	Хуримтлагдсан ашиг	2,238,977,477,687.31	2,462,896,188,206.77
2.3	Эзэмшигчдийн өмчийн дүн	5,194,599,296,644.21	5,418,388,566,163.67
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	6,242,284,476,155.69	6,671,149,886,785.25

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого	3,994,315,977,927.82	3,941,783,553,885.15
2	Борлуулалтын өртөг	1,585,542,823,089.45	1,698,462,071,777.78
	Нийт ашиг (алдагдал)	2,408,773,154,838.37	2,243,321,482,107.37
3	Түрээсийн орлого	191,463,490.49	113,739,098.22
4	Хүүний орлого	7,322,131,791.20	4,189,134,595.33
5	Ногдол ашгийн орлого	5,612,456,125.00	5,466,200,375.01
6	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
7	Бусад орлого	18,989,472,570.20	22,302,994,842.81
8	Борлуулалтын зардал	906,128,201,961.30	905,872,220,840.34
9	Ерөнхий ба удирдлагын зардал	234,700,981,043.10	233,682,090,262.55
10	Санхүүгийн зардал	21,729,890,134.38	29,399,811,559.61
11	Бусад зардал	173,936,414,850.17	263,535,573,210.85
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз гарз	(3,929,332,530.16)	(19,254,967,430.77)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз гарз	(275,671,339.66)	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз гарз	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз гарз	-	-
17	Бусад ашиг алдагдал	8,953,027,553.97	771,732,474.62
	Татвар төлөхийн өмнөх ашиг	1,109,141,214,510.46	824,420,620,189.24
18	Орлогын татварын зардал	306,107,023,210.16	245,892,151,307.78
	Татварын дараах ашиг (алдагдал)	803,034,191,300.30	578,528,468,881.46
19	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал		
20	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	803,034,191,300.30	578,528,468,881.46
21	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Хөрөнгийг дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
	Гадаад валютын хөврүүлэлтийн зөрүүний олз гарз	-	-
	Бусад олз гарз	-	-
22	Орлогын нийт дүн	803,034,191,300.30	578,528,468,881.46
23	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг алдагдал		

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,658,321,900.00	483,770,162,923.12	2,475,166,939,337.00	1,877,421,293,635.79	4,839,016,717,795.91
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
3	Залруулсан үлдэгдэл	2,658,321,900.00	483,770,162,923.12	2,475,166,939,337.00	1,877,421,293,635.79	4,839,016,717,795.91
4	Тайлант үеийн цэвэр ашиг				803,034,191,300.30	803,034,191,300.30
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
6	Өмчид гарсан өөрчлөлт				(31,869,566,502.00)	(31,869,566,502.00)
7	Зарласан ногдол ашиг				415,582,045,950.00	415,582,045,950.00
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(5,973,605,203.22)		5,973,605,203.22	-
10	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,658,321,900.00	477,796,557,719.90	2,475,166,939,337.00	2,238,977,477,687.31	5,194,599,296,644.21
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
12	Залруулсан үлдэгдэл	2,658,321,900.00	477,796,557,719.90	2,475,166,939,337.00	2,238,977,477,687.31	5,194,599,296,644.21
13	Тайлант үеийн цэвэр ашиг				578,528,468,881.46	578,528,468,881.46
14	Бусад дэлгэрэнгүй орлого					-
15	Өмчид гарсан өөрчлөлт				(81,707,574,320.00)	(81,707,574,320.00)
16	Зарласан ногдол ашиг				273,031,625,042.00	273,031,625,042.00
17	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(129,441,000.00)		129,441,000.00	-
	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,658,321,900.00	477,667,116,719.90	2,475,166,939,337.00	2,462,896,188,206.77	5,418,388,566,163.67

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,839,381,990,162.52	3,710,331,287,496.05
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,762,988,642,301.33	3,629,188,840,727.33
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	19,598,956.01	40,241,600.60
1.1.6	Бусад мөнгөн орлого	76,373,748,905.18	81,102,205,168.12
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,266,826,508,173.87	3,104,441,424,176.91
1.2.1	Ажиллагчдад олгосон цалин, урамшуулал	391,065,820,183.35	481,038,424,680.88
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	102,796,754,400.00	117,800,000,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	379,755,179,159.64	306,300,207,773.44
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	344,365,930,413.33	348,486,977,904.92
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	396,527,595,178.89	432,504,533,354.28
1.2.6	Төлсөн хүү	0.00	2,719,917,979.54
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,504,158,375,716.46	1,158,444,691,857.51
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	991,988,122.93	123,195,435.94
1.2.9	Бусад мөнгөн зарлага	147,164,864,999.27	257,023,475,190.40
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	572,555,481,988.65	605,889,863,319.14
2	Хөрөнгө оруулалтын үйл ажилгааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,764,812,793.87	12,295,001,425.01
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	8,200,000.00	0.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		4,921,112,500.03
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	327,561,643.84	2,452,165,687.48
2.1.2	Хүлээн авсан ногдол ашиг	5,429,051,150.03	4,921,723,237.50
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	493,599,273,433.07	547,906,549,319.05
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	455,902,949,452.31	524,956,468,055.22
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,302,632,634.10	2,702,794,070.00
2.2.2	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн /тээгү/	14,537,959,560.44	18,154,025,721.14
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /геологи хайгуул/	4,717,931,786.22	2,093,261,472.69
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	17,137,800,000.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(487,834,460,639.20)	(535,611,547,894.04)
3	Санхүүгийн үйл ажилгааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	348,504,026,184.53	273,933,728,232.46
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	342,058,880,279.35	272,641,460,000.00
3.1.1	Хүү ба урамшууллын орлого	6,445,145,905.18	1,292,268,232.46
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	446,945,920,394.00	355,244,891,420.00
3.2.2	Төлсөн ногдол ашиг /	446,945,920,394.00	355,244,891,420.00
3.3	Санхүүгийн үйл ажилгааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(98,441,894,209.47)	(81,311,163,187.54)
4	Валютын ханшны зөрүү	(2,255,505,925.95)	331,345,229.11
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(15,976,378,785.97)	(10,701,502,533.33)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	63,476,983,970.59	47,500,605,184.62
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	47,500,605,184.62	36,799,102,651.29

2.5 Бизнес төлөвлөгөө, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Д/д	Үйлдвэрлэл, эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 оны гүйцэтгэл	2024 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Хөрс хуулалт	мян.м.куб	13,870.4	15,708.5	15,459.2	(249.3)	98.4
2	Хөрс хуулалтын коэффициент	м.куб/м.куб	0.907	1.015	0.976	(0.04)	96.2
3	Хүдэр олборлолт	мян.тн	39,600.0	40,900.0	41,038.0	138.0	100.3
4	Хүдэр боловсруулалт	мян.тн	37,200.0	38,000.0	38,020.0	20.0	100.1
5	Баяжмалын үйлдвэрлэлт:						
5.1	Зэсийн баяжмал	тн	599,607.0	562,059.2	568,240.0	6,180.8	101.1
5.2	Молибдены баяжмал	тн	5,643.8	5,320.0	5,498.4	178.4	103.4
6	Нийт орлого	сая.төг	4,026,431.5	3,882,158.0	3,973,855.6	91,697.6	102.4
7	Нийт зардал	сая.төг	2,917,290.3	3,096,926.8	3,149,435.0	52,508.2	101.7
7.1.	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	сая.төг	1,585,542.8	1,775,667.0	1,698,462.1	(77,205.0)	95.7
7.2.	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	сая.төг	838,548.9	814,330.8	837,716.7	23,385.9	102.9
7.3.	Борлуулалт маркетингийн зардал	сая.төг	67,579.3	65,021.7	68,155.5	3,133.8	104.8
7.4.	Ерөнхий ба удирдлагын зардал	сая.төг	234,701.0	226,637.5	233,682.1	7,044.6	103.1
7.5.	Үйл ажиллагааны бус нийгмийн шинжтэй болон бусад зардал	сая.төг	190,918.3	215,269.9	311,418.6	96,148.8	144.7
8	Цэвэр ашиг	сая.төг	803,034.2	571,763.2	578,528.5	6,765.3	101.2
9	Төсвийн төлбөрт нийт дүн	сая.төг	1,606,310.9	1,364,352.1	1,548,964.8	184,612.7	113.5
10	Төрийн өмчийн ногдол ашиг	сая.төг	415,582.0	401,517.1	273,031.6	(128,485.5)	68.0
11	Нийт ажиллагчдын тоо	хүн	6,895.0	7,226.0	6,910.0	(316.0)	95.6
12	Нийт цалингийн сан	сая.төг	384,909.0	515,822.6	492,617.0	(23,205.6)	95.5
13	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	мөнгө	68.3	74.9	72.0	(2.9)	96.2
14	Хөрөнгө оруулалт	сая.төг	545,946.8	1,182,345.8	627,772.2	(554,573.6)	53.1

3. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 116,515.6 сая төгрөгийн 14 зөрчил илэрснээс, 103,097.0 сая төгрөгийн 7 албан шаардлага хүргүүлж, 13,419.6 сая төгрөгийн 7 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Аудитын шийдвэр			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<p>Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрт тусгагдсан Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ыг түшиглэн үйлдвэрлэл, технологийн парк байгуулах зорилтын хүрээнд зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах металлург-химийн үйлдвэр, (HL-SX/EW) технологиор катодын зэс үйлдвэрлэх арга хэмжээний ТЭЗҮ-ийн зардалд нийт 4,115.3 сая төгрөгийг зарцуулсан боловч төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүй, ашиглалтад ороогүй байна. Тус арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүйгээс баримт бичигт тусгасан хөрөнгө оруулалтын ажлын төсөвт өртөг нэмэгдэх эрсдэл үүссэн, шаардагдах санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй байна.</p> <p>Түүнчлэн хязгаарлагдмал нөөцтэй балансын бус эсэлдсэн хүдрийн овоолго /үүсмэл орд/ ашиглан адил төстэй (SX/EW) технологиор зэс олборлон боловсруулж, катодын зэс үйлдвэрлэдэг Эрдмин ХХК, Зэс эрдэнийн хувь ХХК-ууд үйл ажиллагаа явуулж байгаагаас цаашид Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын дэргэдэх катодын зэсийн үйлдвэр нуруулдан уусгах замаар зэс боловсруулж, нэмэгдсэн өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн бий болсон орлогоос санхүүжүүлэгч, донор байгууллагын хөрөнгө оруулалт, зээлийн эргэн төлөлтийг төлж чадахгүй байх эрсдэлтэй байна.</p>	1	4,115,319.6			1	4,115,319.6
<p>Монгол-Зөвлөлтийн хамтарсан уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр, ОХУ-ын Ростек корпорацийн хувь эзэмшилтэй Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн үед гэрээ, хэлцэл хийх, худалдан авагч, нийлүүлэгч талтай уулзалт хийх, үйлдвэрийн үндсэн үйл ажиллагааг төлөөлөх зорилгоор үйлдвэрийн бүтцийн нэгж болон ажиллаж байгаа Улаанбаатар хотын төлөөлөгчийн газар 674.1 сая төгрөг, ОХУ-ын Москва хот дах худалдааны төлөөлөгчийн газар 439.3 сая төгрөг, БНХАУ-ын Бээжин хот дах төлөөлөгчийн газар 528.8 сая төгрөг, нийт 1,642.2 сая төгрөгийг зарцуулсан байна.</p> <p>Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газар 2024 оны баталсан цалингийн зардлыг 9.9 сая төгрөгөөр хэтрүүлсэн, гадаад албан томилолтын зардлын</p>	1	1,682,837.5			1	1,682,837.5

<p>төлөвлөгөө батлаагүй байхад нийт 30.7 сая /УБТГ 14.8 сая төгрөг, БХТГ 7.6 сая төгрөг, МХТГ 8.3 сая төгрөг/-ийг тус тус зарцуулсан байна.</p>					
<p>1. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын санхүүгийн тайланд урьдчилж гарсан зардал/тооцооны 55,374.0 сая төгрөгийн үлдэгдэл байгаагаас хуулийн байгууллагад шилжүүлсэн, шүүхийн шатанд байгаа зэрэг 81 хуулийн этгээдийн 17,677.1 сая төгрөгийн урьдчилгааны үлдэгдэл байна. Найдваргүй болох эрсдэлтэй гэрээт ажил, бэлтгэн нийлүүлэгчид олгосон урьдчилгаа үүссэн шалтгаан болон тендерийн баримт бичиг, шалгарсан тендерийн үр дүнгээс үзэхэд анхны гэрээ, хэлцэл байгуулагдсаны дараа тухайн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан урьдчилгаа төлбөрийн нөхцөлийг нэмж тусган төлбөрийг бүрэн олгосон, анх тохирсон хугацаанаас хойш удаа дараа өөрчлөлт оруулж, хугацааг сунгасан зэргээс шалтгаалан захиалагч тал гэрээний хэрэгжилтийг бүрэн хангуулж чадахгүй байх эрсдэлийг үүсгэж байна.</p> <p>2. Аудитын горим гүйцэтгэхэд авлага дансны бусад авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй, хуулийн байгууллагад шилжүүлсэн Ачит ихт ХХК-ийн 3,478.2 сая төгрөгийн, Эрдэнэт-Ус, ДТС ОНӨХК-ийн 15,167.9 сая төгрөгийн, Өргөө констракшн ХХК-ийн 9,766.2 сая төгрөгийн авлагууд байна.</p> <p>3. Мөн 2021 оны 5 дугаар сарын 10-ний өдрийн 6/005 дугаар “Техник, технологийн туршилт боловсруулалтын хамтын ажиллагааны гэрээ”-нд хугацааг тодорхой тусгаагүй, 2022 оны 4 дүгээр сарын 27, 2023 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр хугацааг тодорхойлсон боловч санхүүгийн тайланд 11,485.4 сая төгрөгийн авлагыг хугацаагүй оруулж, насжилтыг тодорхойлоогүй байна.</p>	1	-		1	-
<p>Ашиглалтад байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 546,582.1 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаагаас цаашид ашиглах боломжтой эсэхийг тодорхойлж, ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоогоогүй, санхүүгийн тайланг бодит үнэ цэнээр тайлагнаагүй байна.</p>	1	-		1	-
<p>"Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 50 дугаар тогтоолоор төсөвт төвлөрүүлэх төрийн өмчийн ногдол ашгийг 401,217.1 сая төгрөг байхаар баталсан боловч, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталж, 2024 оны 05 дугаар</p>	1	-		1	-

<p>сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэнтэй холбоотойгоор төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцаа 34 хувь буюу 273,031.6 сая төгрөгийг хуримтлалын санд төвлөрүүлсэн байна.</p> <p>Дээрх бизнес төлөвлөгөө, зорилтот түвшинд баталсан төвлөрүүлэх ногдол ашгийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг аудитаар хөөн шалгахад 62,213.2 сая төгрөгийг нийгмийн шинжтэй хөрөнгө оруулалтын ажилд зарцуулсан байна.</p>				
<p>"Белаз хүнд даацын өөрөө буулгагчийн сэлбэг, эд ангийг худалдан авах" тендерт Бүгд Найрамдах Беларус Улсын Белаз Холдинг ХХК-ийн бүтээгдэхүүн борлуулах албан ёсны эрхтэй Юнайтед мерес машинери ХХК-ийг гэрээний үүргээ биелүүлээгүй шалтгаанаар Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хүсэлтээр "Эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл"-д бүртгэсэн боловч дээрх хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчийн давхар хувь эзэмшилтэй Беллинк ХХК нь Белаз Холдинг ХХК-ийн албан ёсны эрхийг хэрэгжүүлж эхэлсэн байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ авах тухай хууль /шинэчилсэн найруулга/ мөрдөгдөж, нэг эх үүсвэрээс худалдан авах аргыг ашиглаж эхэлсэнтэй холбоотойгоор Беллинк ХХК-тай тайлант онд автомашины сэлбэг 3,872.1 сая төгрөг, хүнд даацын автомашины цахилгаан тоноглолын сэлбэг 3,749.4 сая төгрөг, нийт 7,621.4 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.</p> <p>Аудитаар хянаж үзэхэд Беллинк ХХК нь дээрх байгуулсан 2024/05-20-0435, 2024/05-20-0432 дугаар гэрээнд заасан хугацаанд барааг нийлүүлээгүйгээс алданги тооцох нөхцөл бий болсон, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас 2024 онд зарласан адил төстэй сэлбэг, хэрэгсэл нийлүүлэх нээлттэй тендерт 6 удаа үнийн санал хүргүүлж, оролцогчийн ерөнхий нөхцөлийн шаардлагыг хангаагүй, 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдөр компани байгуулагдсан зэрэг нь цаашид үйл ажиллагаанд ашиглаж буй Белаз маркийн хүнд даацын техникийн сэлбэг хэрэгсэл тасалдах, гэрээний үүргээ хэрэгжүүлэхгүй байх, найдваргүй авлага үүсэх эрсдэл учирч болзошгүй байна.</p>	1	7,621,422.7		1 7,621,422.7
<p>1. Эрдэнэт үйлдвэр ХХК (хуучин нэрээр), Ачит Ихт ХХК-тай 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдөр, 2015 оны 6 дугаар сарын 24-ний өдөр балансын бус хүдрийн овоолгыг ашиглаж, үйлдвэрлэсэн катодын зэсийг боловсруулсан борлуулалтын орлогоос ашиглуулагч талд төлөх төлбөрийн хэмжээг 0.5-2.0 хувийн хооронд жил бүр</p>	1	-	1	

<p>нэмэгдүүлэх байдлаар тохиролцон 2034 он хүртэл ашиглахаар гэрээ байгуулсан боловч талууд борлуулалтын дүнг валютын ханштай уялдуулан ашиглалтын төлбөр, түүнээс хэрхэн НӨАТ тооцох эсэхийг гэрээнд нарийвчлан тохиролцоогүйгээс Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын тооцоолсон 2015-2024 онд Ачит Ихт ХХК-аас авах 3,478.2 сая төгрөгийн овоолго ашигласны төлбөрийн авлагыг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.</p>					
<p>Мөн Ачит Ихт ХХК-тай Эрдэнэт Үйлдвэр ХХК (хуучин нэрээр) байгуулсан 2010, 2013 оны гэрээгээр талууд харилцан тохиролцсон 34 хувьд ногдох ногдол ашгийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т нөхөн төлүүлэх, овоолго ашиглалтаас байгаль орчинд учирсан хохирол, байгаль орчны нөхөн сэргээлтийн төлбөрийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж, зохих төлбөрийг гаргуулах талаар шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг төрийн захиргааны байгууллагуудад даалгасан боловч Ачит Ихт ХХК ногдол ашгийг нөхөж төлөөгүй байна.</p>					
<p>2. Эрдэнэт үйлдвэр ХХК (хуучин нэрээр) Эрдмин ХХК-тай 2005 оны 10 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан "Бизнесийн гэрээ", "Эрдэнэтийн эрдсийн уусмал" буюу "Эрдмин" ХХК-ийн дүрэм /нэмэлт, өөрчлөлтийн тусгасан хувилбар/-д заасны дагуу тус хуулийн этгээдийн 25 хувийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ эзэмшдэг байна. Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Эрдэнэт үйлдвэр ХХК, Зэс Эрдэнийн хувь ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлтэй 2013 оны 05 дугаар сарын 02-ний өдөр байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-гээр тус үйлдвэрийн 34 хувийг Эрдэнэт үйлдвэр ХХК эзэмшихээр гэрээ байгуулсан боловч 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдөр "Исэлдсэн хүдрийн овоолго ашиглах гэрээ"-г шинэчлэхдээ ашигт малтмалын үүсмэл орд эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоогоогүй байна.</p>					
<p>Санхүүгийн тайланд бүртгэлтэй 822.4 сая төгрөгийн өр төлбөрийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.</p>	1	-	1		
<p>Татварын тайлан, төлөлт, ногдуулалттай холбоотой дараах зөрчлүүд байна. 1. Тус үйлдвэрийн 2023 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулсны дараа ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлангаар ногдуулсан дүнг өөрчилж, өр төлбөрийг нэмэгдүүлэн тайланг засаж 1,197.9 сая төгрөгийн төлбөрийг төлсөн; 2. Тайлант оны 1 дүгээр сарын</p>	1	-	1	-	

нэмэгдсэн өртгийн албан татвар, 4 дүгээр улирлын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайланг баталгаажуулаагүй; 3. Татварын ерөнхий хуулийн дагуу тайлагнасан дотоод үнэ шилжилтийн тайлан баталгаажуагүй, ерөнхий үнэ шилжилтийн тайланг үнэн зөв тайлагнасан эсэх нь тодорхой бус байна.						
Өмнөх онуудад үүссэн Медипас ХХК, Медипас нийгэмлэгийн нэхэмжлэлтэй холбоотой асуудлаар Сингапурын Олон Улсын Арбитрын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 12 дугаар шийдвэрээр Эрдэнэт үйлдвэр ХХК (хуучин нэрээр), Медипас ХХК, Медипас нийгэмлэгтэй хүчин төгөлдөр бус гэрээ байгуулсан гэх үндэслэлээр Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас 29,285,938.58 ам.доллар буюу 101,874.2 сая төгрөгийг гаргуулан төлүүлэх шийдвэр гарсан байна. Тус шийдвэрийн дагуу Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс 10 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх 20 хоногийн хугацааны хүү 202.3 сая төгрөг, албадан ажиллагааны зардал 2.5 сая төгрөг, нийт 102,079.0 сая төгрөгийг үйлдвэрийн бизнес төлөвлөгөө, эдийн засгийн зорилтот түвшинд тусгаагүй зардлыг төлснөөр мөнгөн хөрөнгийн зохистой удирдлага алдагдсан байна.	1	102,079,057.9	1	102,079,057.9		
Орхон аймаг дах цагдаа, дотоодын цэргийн байгууллагатай байгуулсан гэрээг үндэслэн өндөр насны тэтгэвэрт гарахад олгосон нэг удаагийн тэтгэмжийн 719.0 сая төгрөгийг байгууллагын дансанд шилжүүлэхгүй, хувь хүний дансанд шилжүүлсэн байна.	1	719,063.1	1	719,063.1		
Тайлант онд 229.0 сая төгрөгийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй дараах хандив, тусламжийг хууль, тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр олгосон байна.	1	229,000.0	1	229,000.0		
Сангийн сайдын баталсан гадаад, дотоод албан томилолтын зардлын хэмжээг мөрдөөгүй, томилолтын болон сургалтын зардлын хэмжээг томилолтоор ажиллах ажилтны албан тушаалаар ялгаатай буюу харилцан адилгүй тогтоон Тамгын дарга баталж, тайлант хугацааны албан томилолтын зардлаас 420-г түүвэрлэн шалгахад 69.9 сая төгрөгийн албан томилолтын зардлыг Сангийн сайдын баталсан тарифаас илүү тооцож олгосон байна.	1	69,898.7	1	69,898.7		
Тайлант оны худалдан авалтын төлөвлөгөөнд баталсан технологийн шохойг нэг эх үүсвэрээс худалдан авах ажиллагааны арга ашиглан 2 хуулийн этгээдээс нийт 14,650.8 сая төгрөгийн гэрээ байгуулан худалдан авалт хийсэн байна.	1				1	
Нийт дүн	14	116,516,599.5	7	103,097,019.7	7	13,419,579.8

3.2. АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 28,112.2 сая төгрөгийн 3 асуудалд зөрчлийг таслан зогсоох, сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага тус тус хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Аудитын шийдвэр					
			Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны мэдээллийн системд цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүнтэй орлогын гүйлгээний 3,996,847.6 сая төгрөгийн 2051 гүйлгээ мэдээлэхээс 27,887.9 сая төгрөгийн 27 гүйлгээг мэдээлээгүй, зарлагын 3,906,781.5 сая төгрөгийн 3770 гүйлгээ мэдээлэхээс 224.2 сая төгрөгийн 16 гүйлгээ, нийт 28,112.2 сая төгрөгийн 43 гүйлгээг мэдээлээгүй байна.	1	28,112,192.0					1	28,112,192.0
Дүн	1	28,112,192.0	-	-	-	-	1	28,112,192.0
Уул уурхайн экспортын бүтээгдэхүүнийг Нэг цонхны бодлогоор арилжаалах зорилтын хүрээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр арилжаалахаар санал болгож буй зэсийн баяжмалын үнийг тооцсон цэвэр зэсийн үнийг тайлант оны 8 дугаар сарын байдлаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас санал болгосон "LME 3 month futures closing price" 7 хоногийн дундаж үнээр, хайлуулах зардлыг 1 хуурай метр тонн тутамд 15 ам.доллар, цэвэршүүлэх зардлыг 8 ам.доллаар тогтмол байдлаар тооцож, арилжааны дуудах доод үнийг зах зээлийн үнээр бус хатуу тогтоосноос худалдан авагч үнийн санал ирүүлэхгүй, бүтээгдэхүүн арилжаалагдахгүй байх эрсдэлийг бий болгосон байна.	1	-	1					
Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын жилийн эцсийн байдлаар худалдан авсан 116 ажлын 274,827.3 сая төгрөг, 699 бараа материалын 609,848.0 сая төгрөг, 54 үйлчилгээний 27,081.1 сая төгрөгийн нийт 869 гэрээ хэлцлийн 911,756.5 сая төгрөгийн гэрээ, хэлцэл түүний хэрэгжилтийг цахим системд ил тод, нээлттэй хөтөлж, мэдээлээгүй байна.	1	-	1					
Дүн	2	-	2	-	-	-	-	-
Нийт дүн	3	28,112,192.0	2	-	-	-	1	28,112,192.0